



СЭЛЭНГЭ АЙМАГ  
ЦАГААННУУР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 04 сарын 05 өдөр

Дугаар 50.

Хуурч

Хоршоо хөгжүүлэх сангийн хөрөнгийн  
зарцуулах чиглэл тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын 2021 оны А/361 дугаар тушаалаар батлагдсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг.Хоршоо хөгжүүлэх сангийн хөрөнгийг ажлын байр бий болгох, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, амьжиргааг сайжруулах, орон нутгийн тогтвортой хөгжлийг хангах зорилгоор:

1. Арьс шир, ноос ноолуур боловсруулах
2. Мал үржлийн технологийн ажил үйлчилгээний нэгжийг дэмжих
3. Мал нядалгааны цех байгуулахад дэмжлэг үзүүлэх
4. Нарийн боовны цехийн өргөтгөлд дэмжлэг үзүүлэх
5. Авто угаалга, засварын газар шинээр барих болон өргөтгөхөд дэмжлэг үзүүлэх чиглэлээр зээл олгон зарцуулсугай.

Хоёр.Чиглэлийн дагуу олгосон зээлийн үйл ажиллагаанд нь хяналт тавьж, санхүү болон үйл ажиллагааны тайланг жил бүр иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж байхыг сумын Засаг дарга /Ц.Баянбаатар/-т даалгасугай.

ДАРГА

Г.ЦЭНДСҮРЭН

